МОНГОЛ УЛС
ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ
Магадлалын дүгнэлтийн дугаар 0264/2025
МАГАДЛАЛ ХИЙГДСЭН
Магадлал хариуцах
Хэлтсийн дарга: .....
/Гарын үсэг/
20 25 оны 02 сарын 27 өдөр

БАТЛАВ:

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР:..... / Б.БЯМБАДОРЖ /

Зургийн шифр. TS-US-02/2024

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ, ДАРИВ СУМ "ХАРГАНА ТҮРҮҮГИЙН УСЛАЛТЫН СИСТЕМИЙН ЗАСВАР ШИНЭЧЛЭЛТ"-ИЙН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ

/АЖЛЫН ЗУРАГ/

ЗӨВШӨӨРСӨН:

АЛБАН ТУШААЛ		НЭР	ГАРЫН ҮСЭГ
	ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА	Ц.ЛУВСАНЖАМЦ	
АЛБАН ТУШААЛ		НЭР	ГАРЫН ҮСЭГ
	ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЭМГ-ИЙН ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН ҮЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ	О.МӨНХБААТАР	

БОЛОВСРУУЛСАН:

ЗАХИАЛАГЧ:			
	ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА	НЭР	ГАРЫН ҮСЭГ
		Г.ЧИНБАТ	
ГҮЙЦЭТГЭГЧ:			
	"ЦЭГЦ ЗУРАГЛАЛ ПРОЖЕКТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ	НЭР	ГАРЫН ҮСЭГ
		И.БААСАНДУЛАМ	

2024 ОН

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ 2

2. БАЙГАЛЬ ЦАГ УУРЫН НӨХЦӨЛ 3

2.1 Физик газарзүй 3

2.2 Уур амьсгалын нөхцөл 4

2.2.1 Агаарын температур 4

2.2.2 Хөрсний температур 4

2.2.3 Хур тундас: 4

2.3 Цасан бүрхүүл. 4

2.4 Агаарын чийгшил. 4

2.5 Салхи. 4

2.6 Ууршилт: 5

3. ХАРГАНА ТҮРҮҮГИЙН БУЛГИЙН УС ЗҮЙ 6

3.1 Олон жилийн дундаж урсац 6

3.2 Их урсац 6

3.3 Ууршилт. 7

4. ТАЛБАЙН ИНЖЕНЕР ГЕОЛОГИ 8

4.1 Талбайн гидрогеологийн нөхцөл 8

5. ХӨРСНИЙ МЕЛИОРАЦИЙН СУДАЛГАА БА ТАРИМЛЫН УСАЛГААНЫ ГОРИМ, НОРМ 9

5.1 Хөрс мелиорацийн нөхцөл 9

5.2 Мелиорацийн мужийн тухай ойлголт 11

6. ТАРИМЛЫН УС ХЭРЭГЛЭЭ БА УСАЛГААНЫ ГОРИМ, НОРМ 12

6.1 Таримлын ус хэрэглээний коэффициент 12

6.2 Таримлын нийт ус хэрэглээ 12

6.3 Таримлын усалгааны горим, норм 13

7. ЗУРАГ ТӨСЛИЙН ТЕХНИКИЙН ШИЙДЭЛ БА ҮЗҮҮЛЭЛТ 15

7.1 Ус өгөх хоолой 1,2 15

7.2 Дөхүүлэх суваг 15

7.3 Гол суваг-1,2 15

7.4 Хувиарлах суваг 15

7.5 Усан сан 15

7.5.1 Усан сангийн хийц, зохиомж 15

7.5.2 Далангийн хийц 15

7.5.3 Сангийн ёроолын хийц 16

8. АЖЛЫН ТЕХНОЛОГИ 16

8.1 Усан сан барих ажлын технологи 16

8.1.1 Газар шорооны ажил 16

8.1.2 Талбайн бэлтгэл ажил 16

8.1.3 Шимт хөрс хуулах 16

8.1.4 Суурийн бэлтгэл 17

8.1.5 Хөрсний сонголт 17

8.1.6 Талбайн туршилт 17

8.1.7 Хөрсийг дэвсэх, нягтруулах болон туршилт хийх 17

8.1.8 Далангийн хөрсний овоолгын ажил 18

8.1.9 Доторлогооны геомембран үе 18

8.1.10 Геомембран доторлогооны туршилтын төлөвлөлт 19

8.2 Ус өгөх шугам хоолой барих ажлын технологи 19

8.3 Гол суваг барих ажлын технологи. 19

8.4 Үерийн хамгааалатын даланг сэргээн засварлах ажил 19

8.5 Үеийн зузааныг хянах болон маркшейдерийн шаардлагууд 19

9. ЗӨВЛӨМЖ 20

9.1 Зохиогчийн зөвлөмж 20

9.2 Байгаль орчин, хөдөлмөрийн аюугүй байдал, эрүүл ахуй 20

9.3 Ерөнхий шаардлага 21

10. АШИГЛАСАН ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ 22

1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Услалтын системийн өмчлөгч, эзэмшигч: Говь-Алтай аймаг, Дарив сумын засаг даргын тамгын газар

Услалтын системийн хайгуул, зураг төсөл зохиогчид:

- Зураг төсөл, зөвлөх үйлчилгээний "ЦЭГЦ ЗУРАГЛАЛ ПРОЖЕКТ" ХХК
- Геодезийн хэмжилт, байр зүйн зураглалыг " ДОПЛЕР ИНЕРЦ" ХХК

Услалтын системийн нэр, хийцийн ангилал: Инженерийн хийцтэй, ил систем

Услалтын системийн байршил: Говь-Алтай аймгийн Дарив сумын нутагт сумын төвөөс баруун хойт зүгт 14 км зайд, Ихэс нуурын дэргэд N 480 31' 880'', E 0940 00' 108'' собицолд оршино.

УСЛАЛТЫН СИСТЕМИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН БҮТЭЦ

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
			Шинээр төлөвлөх
1	Услах системийн талбай	га	181
2	Усны эх булаг: Харганатүрүүний булаг	л/сек	
3	Ус авах толгой барилга	ш	1
4	Ус өгөх хоолой-1 PE100 SDR17 OD400 мм	у.м	106
5	Ус өгөх хоолой-2 PE100 SDR17 OD400 мм	у.м	404
6	Ус хуримтлуулах, дамжуулах сан-1	$м^3$	V=13182.2
7	Ус хуримтлуулах, дамжуулах сан-2		V=17814.6
8	Гол суваг-1 b=0.6м, h=0.6м	у.м	1444
9	Гол суваг-2 b=0.6м, h=0.6м	у.м	1127.5
10	Хуваарилах суваг b=0.6м, h=0.3м	у.м	6956
11	Дөхүүлэх суваг	у.м	60
12	Тохируулах худаг	ш	1
13	Ус авах, нөөц хоолой 1.2	ум	80
14	Ус авах худаг	ш	2

ТӨСЛИЙН ЗОРИЛГХО, АЧ ХОЛБОГДОЛ

Дэлхийн цаг агаарын дулаарал нь эх газрын эрс тэс уур амьсгалтай манай орны байгаль цаг уурын нөхцөлд таагүй нөлөө үзүүлэх магадлал өндөр байна. Зураг төслийн объект байрлаж буй Говь-Алтай аймгийн Дарив сумын нутаг дэвсгэр нь байгаль цаг уурын хувьд хуурайвтар сэрүүн уур амьсгалтай бөгөөд жилд орох хур тунадасны хэмжээ төвийн аймгуудтай харьцуулахад бага, ургамлын бүрхэвчийн хувьд тачир сийрэг юм. Сүүлийн жилүүдэд Алтай нурууны мөнх цас, мөсөн голуудын талбайн хэмжээ багассан, гантай жилүүдийн давтамж нэмэгдсэн зэрэг нь энэ бүс нутагт таримал ургамлыг зөвхөн усалгаатайгаар эрхэлж тогтвортой өндөр ургац авах нөхцлийг улам лавшруулж байгаа юм.

Говь-Алтай аймгийн Дарив сумын Харгана түрүүний услагдах талбай нь Ихэс нуурын захад байрлах бөгөөд усалгаатай газар тариалан эрхлэхэд ихээхэн тохиромжтой хөрстэй юм. Урьд өмнө хийгдэж байсан хайгуул судалгаа, зураг төслийн материалаас үзэхэд энд усалгаатай газар тариаланд ашиглах боломжтой нийт 300 орчим га газар байна гэж тогтоож байсан байна.

Төр засгаас газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг тууштай баримталж, услалтын системийг шинээр байгуулах, сэргээн засварлахад зориулан улсын төсвөөс хөрөнгө оруулалт хийх болсноор усалгаатай газар тариалангийн хэмжээ нэмэгдсэн нь хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, өөрсдийн газар шороон дээр эрүүл аюулгүй орчинд ургуулсан гурил, төмс хүнсний ногоог хэрэглэх, малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд, орон нутагт ажлын байр буй болгох зэрэг нийгмийн олон асуудлыг нааштайгаар шийдвэрлэх боломжийг олгож байна.

Харгана түрүүний услалтын систем нь 173 га талбайг услах хүчин чадалтайгаар баригдаж анх 1984 онд ашиглалтанд орсон бөгөөд 1991 оны намар хүртэл хэвийн ашиглагдаж байгаад зах зээлийн шилжилтийн эхэн үед эвдэрч тоногдон ашиглалтаас гарсан байна. Энэ нь услалтын системийг ашиглахтай холбоотой хөрөнгө мөнгөний хүндрэл гарсан, тариалж байсан зарим төрлийн таримал, ялангуяа малын тэжээлийг худалдан борлуулах зах зээлгүй болсон, услалтын системийн барилга байгууламж, тоног төхөөрөмж элэгдэж хуучирсан, тэдгээрийг сэргээж засварлахад шаардагдах сэлбэг материалын олдоц ховордсон зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой боловч гол нь услалтын системийн тоног төхөөрөмжийг үрэн таран хийн зарж борлуулан ашиг хонжоо олох сонирхол бүхий этгээдэд хувьчилж өгсөнөөс услалтын системийн ус дамжуулах далд хоолойг нийтэд нь ухаж авсаны дээр булгийн усыг цуглуулж хуримтлуулах усан сан, насос станцын зогсоол зэргийг эвдэж тонон ажиллагаагүй болгосон байна. Хуучин услалтын системийн

талбайд 2008 оноос цөөн тооны хувь хүмүүс 5 орчим га талбайд гар аргаар усалгаа хийн төмс, хүнсний ногоо, бага зэрэг арвай тариалж эхэлсэн байна. .

Харгана түрүүний услалтын системийн талбайн хайгуул судалгаа, ажлын зураг төслийг усны барилга байгууламжийн зураг төслийн мэргэжлийн байгууллага "Цэгц зураглал прожект" ХХК-ны инженерүүд боловсруулав. Төслийн бүрэлдэхүүнд

- Тайлбар бичиг
- Ажлын зураг
- Ажлын төсөв

Зураг төсөлд урьд өмнө хийгдэж байсан хайгуул, судалгаа, зураг төслийн материалыг ашигласан болно

Өмнө ашиглагдаж байсан Харгана түрүүний услалтын систем нь бүрэн эвдэрч тоногдсоны дээр ашиглалтын зардал өндөртэй байх техникийн шийдэлтэй байсан тул хуучин байдлаар нь сэргээн засварлах шаардлагүй гэж үзсэн болно. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ, боломжоос хамаарч Харгана түрүүний услалтын системийг нийт услагдах талбайг хамруулан шинээр барих боломжгүй байгаа тул энэ удаад усалгааны усыг авах нөхцлийг найдвартай болгох, гол сувгийг шинээр барих асуудлыг энэхүү төсөлд тусгасан болно. Гол суваг талбайн дээд талаар байрлах тул талбайн аль ч цэгт усыг өөрийнх нь урсгалаар хүргэж усалгаа хийх боломжтой болно.

2. БАЙГАЛЬ ЦАГ УУРЫН НӨХЦӨЛ

2.1 Физик газарзүй

Төслийн объект болох Харгана түрүүний услалтын систем нь Говь-Алтай аймгийн Дарив сумын нутагт, Шаргын говийн хойд үзүүрт оршино. Энэ газар нутаг нь газар зүйн байрлалын хувьд Монгол Алтайн нурууны уулархаг мужид хамаарагдах бөгөөд Монгол Алтайн нурууны зүүн хэсэгт өндөр уулын хоорондох хөндийд урд талаараа Сутайн уулсаар, зүүн хэсгээрээ Дарвийн нуруугаар, баруун хойд ба зүүн урд хэсгээрээ Их нурууны хотгорт багтах салбар хөндийнүүдээр хүрээлэгдэж оршино.

Зураг 2.1. Услалтын системийн талбайн физик-газар зүйн байршлын зураг

Услалтын системийн талбай нь Дарив сумын төвөөс баруун хойт зүгт 14 км зайд, Ихэс нуурын дэргэд байрлана. Төслийн объектийн байрлалын координат N 480 31' 880'', E 0940 00' 108''

Харгана түрүүний услалтын талбайд хүрэх зам , харилцаа саадгүй, цахилгааны эх үүсвэрээс 14км зайтай, Улаанбаатар хотоос 1410 км, Говь-Алтай аймгаас 198км зайтай оршино.

2.2 Уур амьсгалын нөхцөл

Цаг уурын тодорхойлолтуудыг Говь-алтай аймгийн Дарив сумын цаг уурын станцын мэдээллээр төсөлд тусгав. Энэхүү станци нь төслийн объектоос 14 км зайд оршино. Төслийн объект нь цаг уурын бүсчилэлээр Шаргын говийн нутаг дэвсгэрт хамрагдана . Шаргын говь орчмын нутгийн уур амьсгал нь Монгол орны бусад бүх нутгийн нэгэн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай хуурай мужид багтана. Алтайн их мужийн хамгийн өндөр нурууд нь зөвхөн баруун хойд захаар оршдог учраас баруун зүгээс ирэх чийгтэй агаарын урсгал энд орж ирэхгүй харин зүүн, зүүн урд талаасаа нээлттэй болохоор говийн хуурай амьсгал нэвтрэн орж ирэх боломжтой байдаг байна. Иймд энэ нутаг ихэвчлэн хуурай уур амьсгалтай байдаг байна. Шаргын говийн хонхорт зун нь их халуун боловч хур тунадастай үед агаарын чийг нэмэгдэнэ. Намар хур тунадас эрс багасдгийн улмаас харьцангуй чийг багасаж агаарын температур аажмаар буурна. Өвлийн улиралд хүйтний эрч удаан үргэлжлэх ба бага зэрэг цас орно. Хавар агаарын чийг багасаж, салхитай өдрийн тоо нэмэгдэж үе үе шороон шуурга болно.

2.2.1 Агаарын температур

Олон жилийн дундаж агаарын температур +0.3°С. Хамгийн хүйтэн сар болох I сард агаарын дундаж тепературт -21.3°С, ажиглалтаар хамгийн бага тепмператур -48°С гэж тэмдэглэгдсэн. Хамгийн дулаан сар болох YII сарын дундаж температур 18.9°С, хамгийн их температур 35.4°С болно. Агаарын температурын хамгийн их агаарыг 33.4°С, хоногийн дундаж агаарын температур 0°С–ыг хавар 03.IY-нд намар 19.X-нд дайрч өнгөрнө. Вегетацийн үеийн эхлэх хугацаа буюу +10°С-ыг хавартаа дунджаар 10.Y-нд, намартаа дунджаар 18.IX-нд тус тус дайран өнгөрнө. Хүйтрэхгүй үе жилд дунджаар 198 хоног үргэлжлэх ба сүүлийн болон эхний хүйтрэлт дунджаар 3.IY-нд 19.X-нд тус тус ажиглагдана.

2.2.2 Хөрсний температур.

Агаарын сарын дундаж температуртай харьцуулахад хөрсөн дээрх сарын дундаж температур нь өвөлд 0.4^0с -2^0с-ээс бага, $3,3^0$с-ээс их хэмжээтэй байдаг. Төслийн раойнд улирлын хөлдөлт 2.15-3.17м гүнд явагдана. 1-р хүснэгтэнд янз бүрийн гүнд хөрсний температурын 0^0с-т шилжих хөрсний температурын шилжилтийн цаг хугацааг үзүүлэв.

Хүснэгт-1

Улирал	Гүн /м/				
	0,4	0,8	1,2	1,6	2,4
Хавар-зун	04.IV	11.IV	20.IV	26.IV	10.V
Намар-өвлийн	08.XI	24.XI	12.IX	24.X	10.11

2.2.3 Хур тундас:

Судлагдаж буй талбай нь хүрэлцээтэй бус чийгшлийн бүсэд хамаарагдана. Хур тундасны олон жилийн дундаж 119 мм. (2-р хүснэгт) Хур тундасны дийлэнх хувь буюу 86% нь (102 мм) V-IX сард унана.

2.3 Цасан бүрхүүл.

Тус районд хүйтний улирал харьцангуй урт бөгөөд бага цас унадаг. Цасан бүрхүүл XII-р сарын сүүлчээр тогтон 3-р сарын адгаар хайлж дуусдаг ба жилд дунджаар 110 хоногт тогтвортой цасан бүрхүүлтэй байна. Цасан бүрхүүлийн хамгийн их зузааны дундаж нь 4 см, хамгийн зузаан нь 10 см байна

2.4 Агаарын чийгшил.

Олон жилийн дундаж агаарын үнэмлэхүй чийгшил 4.5мб, үнэмлэхүй чийгшлийн бага утга нь 1-2 дугаар сард 0.7-0.9мб, 3-р сараас эхлэн 7-р сард 10.8 мб болж өсөөд 8-р сард аажмаар, 9-р сараас эхлэн огцом буурна. Агаар дахь усны мөхлөгийн уян налархай шинж чанарын олон жилийн дундаж 4,5 мб хүрнэ.

Олон жилийн дундаж харьцангуй чийгшил 55% бөгөөд түүний хамгийн их утга өвөлд /76%/ хамгийн бага утга нь хаварт ажиглагдана. Харьцангуй чийгшлийн хоногийн явцын өөрчлөлтөөс өдөр 36-43%, шөнө 59-43% байна. Дутагдал чийгшил жилд дунджаар 5.7 мб, хүйтний улиралд 0.3-0.5 мб, хавар чийгшил эрс буурахаар нэмэгдэж IY-Y сард 6.7-9.3 мб, зуны YI-YII сард хамгийн их болж 12.6-12.7 мб-д хүрнэ. Дутагдал чийгшлийн хоногийн хамгийн их утга 13 цагт ажиглагддаг ба 7-р сард 18.6 мб хүрнэ. Усны мөхлөгүүдийн агаарын найрлаганд оролцох жилийн дундаж утга 5.7 мб байдаг.

2.5 Салхи.

Олон жилийн дундаж салхины хурд 1.8 м/с, салхины зонхилох чиглэл ихэвчлэн шөнөдөө өмнө, IY-IX саруудад баруун өмнө, зүүн өмнө зүгээс байна.

2.6 Ууршилт:

1957-2004 оны хоорондох агаарын температур ба чийгийн талаар судалгааны материалыг ашиглан М.И.Будиковын аргачиллаар хөрсний гадаргуугаас ууршиж ууршилтыг 115мм гэж тооцсон байна. Олон жилийн ууршилтын дундаж утгыг Д. Зайцовын томъёогоор тооцож үзэхэд 737мм байна. Вариацын итгэлцүүр судлагдаж буй талбайн хувьд (Cv)=0.15, Cs=0.0 гэж үзжээ. Цаг уурын олон жилийн дундаж үзүүлэлтүүдийг 2-р хүснэгтэнд үзүүлэв.

Цаг уурын олон жилийн дундаж үзүүлэлт (Даривын цаг уурын станцын өгөгдөл)

Хүснэгт-2

Шинж чанар		Сарууд												Дундаж
		I	II	III	IY	Y	YI	YII	YIII	IX	X	XI	XII	
Агаарын температур / ^{0}с-ээр /														
Сарын дундаж		-25.4	-20.8	-7.3	3.8	11.5	17.5	18.9	16.9	10.4	1.3	-10.1	-20.3	0.3
Үнэмлэхүй их		8.7	9.9	17.4	30.7	30.9	34.2	35.4	35.1	30.1	25.3	14.0	12.6	35.4
Үнэмлэхүй бага		-4.8	-42.7	-35.8	19.7	-9.9	-6.4	-1.5	-1.9	13.9	-23	-33.9	-45.8	-48
Агаарын чийгшилт /1985-2004/														
Харьцангуй	%	76	72	55	41	39	47	79	51	49	51	59	73	55
Үнэмлэхүй	мб	0.7	0.9	2.1	3.4	5.4	8.2	10.8	9.6	6.2	3.5	1.9	1.0	4.5
Дутмаг	мб	0.3	0.5	2.1	5.7	9.3	12.6	12.7	10.8	7.6	4.3	1.5	0.5	5.7
Тундас														
Дундаж	мм	1.6	1.2	1.7	5.4	13.1	17.7	34.3	27.6	9.6	3.2	1.5	2.1	119
Хамгийн их	мм	7.0	8.3	7.0	19.4	42.0	80.0	119	99.0	44.8	45.1	10.6	8.7	229
Хамгийн бага	мм	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	8.6	2.2	0.0	0.0	0.0	0.0	54.0
Салхины хурд /1985-2004/														
Сарын дун	м/с	0.9	1.3	2.0	2.7	2.8	2.3	1.8	1.7	1.8	1.9	1.7	1.0	1.8
Гадаргуугын чөлөөт ууршилт														
Олон жилийн, мм		-	-	-	86	134	143	127	108	83	56	-	-	737
20% алдагдал, мм		-	-	-	97	151	161	143	122	93	63	-	-	830
Хуурай гадаргуугын ууршилт														
Олон жилийн, мм		1	2	2	9	16	22	22	20	12	6	2	1	115
80% алдагдал, мм		1	2	2	8	14	19	19	17	10	5	2	1	100

3. ХАРГАНА ТҮРҮҮГИЙН БУЛГИЙН УС ЗҮЙ

Шаргын говийн хойд үзүүрт Монгол Алтайн нурууны зүүн хэсэгт орших Харгана түрүүний булаг нь баруун булаг, дунд булаг, зүүн булаг гэгдэх гурван булгаас эх авч 5 км орчим урсаад Ихэс нууранд цутгана. Ихэс нуур нь орчин тойрондоо хужир, марз, давст бүхий говийн нуур болно.



Зураг-2. Харгана түрүүний баруун болон зүүн булаг.

Харгана түрүүний булгийн урсгалын хурд харьцангуй их, гольдрол нь гүн, эрэг нь эгц (эргийн өндөр нь 0.8-1.0м орчим) бөгөөд гольдролын хоёр талыг даган бага зэрэг бут, сөөг ургасан байна. Булгийн ус адаг руугаа бага зэрэг булингартай, цайвар өнгийн болох боловч хүн малын ундаанд тохиромжтой. 1979 оны 5-р сард хийсэн судалгааны дүнгээс үзэхэд усны эрдэсжилт 212 мг/л, булингар 199 мг/л байжээ.

3.1 Олон жилийн дундаж урсац

Харгана түрүүний булгийн усны горим, химийн найрлагыг урьд өмнө судалж байгаагүй байна. Харин 1971-1979 онд хэд хэдэн удаа усны зарцуулгыг хэмжиж, химийн найрлага болон булингарыг нь тодорхойлсон байна.

Харгана түрүүний булгийн усны өнгөрөлтийг (зарцуулгыг) хэмжиж тодорхойлсон олон жилийн ажиглалтын материал байхгүй болно. Урьд өмнө хийгдсэн хайгуул судалгаа, зураг төслийн ажилд тусгагдсан болон орон нутгийн иргэдээс авсан аман судалгааны материалд тулгуурлан усалгаанд авах Харганатүрүүний булгийн зарцуулгыг (өнгөрөлтийг) татруу устай жилийн дунджаар (75%-ийн хангамшил) бодож Q_{75} = 80л/с=0.08 $м^3/с$ гэж тооцоонд авсан болно.

Жилийн доторхи урсацын хувиарлалтыг мөн нутгийн хүмүүсийн яриаг үндэслэн дараах байдлаар төсөлд авав. Харгана түрүүний булаг өвөлд XI-III сард хөлдөх боловч тошин, халиа их үүснэ. Өвлийн улиралд үүссэн халианы хайлбараар IY-Y сард урсац нилээд ихэсч 0.15 $м^3/с$ орчим байх ба YI-IX сард багасдаг байна.

2024 оны 07 дугаар сарын 25-.ны өдөр хийсэн хэмжилтээр Дунд булаг 220 л/с, Хойт булаг (зүүн булаг) 148 л/с байсан нь 1979 онд хийсэн хэмжилт судалгааны материалтай харьцуулахад ойролцоо байгаа нь Харгана түрүүний булгууд тогтмол урсацтай, сүүлийн жилүүдэд урсац хэвийн байгаа гэдгийг харуулж байна.

3.2 Их урсац.

Харгана түрүүний баруун болон дунд булгын эхээр Цагаан гол, зүүн булгийн эхээр Модотын сайр үер ирж энэ орчмын талбай үерт автдаг байна. 1979 оны хайгуул судалгааны үед Түрэгийн сайрын (Модотын сайр) хөндлөн огтлол дээр их усны мөрөөр үерийн усны зарцуулгыг тооцоолж үзэхэд 13.8 $м^3/с$ орчим байсан байна. Сайруудын үерийн ус булгийн тархи, талбайн захруу орж услагдах талбайг бүхэлд нь усанд автахаас хамгаалах зорилгоор өмнө хийгдсэн үерийн хамгаалалтын даланг сэргээн засварлах шаардлагатай гэж үзэв.

Харгана түрүүний услалтын систем барих анханы зураг төслөөр үерээс хамгаалах далан төсөлөж баригдсан бөгөөд ашиглалтын явцад эвдэнч, сэтэрсэн байна.

Өмнө хийсэн төслөөр эдгээр голуудын үерийн талаар тодорхой зүйл байхгүй байгаа тул шинээр их урсацын тооцоо хийв.



Зураг -3. Харгана түрүүний булгийн эхруу ирэх гол, сайруудын ус хурах талбай

Цагаан гол: Цагаан гол нь Сутай хайрхан уулын араас эх авч эхэн хэсэгтээ байнгын урсацтай байдаг. Хур бороо багатай үед Хонгор толгойгоос доош уулнаас мултарч олон салаалан говийн сэвсгэр хурдсанд шургадаг, хаврын шар усны болон хур борооны үертэй гол юм, Энэ гол дээр байнгын хэмжилт судалгаа хийж байгаагүй. Хаврын шар усны болон зуны хур борооны үер ихээхэн эрчимтэй явагддаг гол юм.

Модотын сайр болон түүний хойт талын жижиг сайрууд Даривын нурууны өвөөс эх авдаг байна.

Эдгээр гол сайруудын их урсацын тооцоог хийж гүйцэтгэхийн тулд М1:100 000-ийн байр зүйн зураг, "Googlr Eart Pro" сансарын зураг болон хайгуул судалгааны материалыг ашиглав. Тухайн газар нутаг нь Монгол орны уруйн үер эрчимтэй болж өнгөрдөг мужид хамаарагдах бөгөөд богино хугацаанд эрчимтэй орсон борооны улмаас их хурдтай үер бууж ирдэг онцлогтой. Хээрийн судалгааны явцад усжих талбайг байр зүйн зурагт буулгаж ус хурах талбайн ерөнхий байдал, ургамалшилт, хөрсний бүтэц зэрэгт бичлэг хийлээ.

Судалгаагүй сав газрын / гол горхи, хуурай сайр / хур борооны үерийн усны хамгийн их урсацын тооцоог хур борооны эрчимшилийн аргаар тооцож гаргав. Хур борооны үерийн урсац нь хоногт хэдий хэмжээний хугацаанд ямар эрчимтэй орсон борооны байдлаас шалтгаалдаг тул хур борооны үерийн их урсацын тооцоонд 1%-ийн хангамшилтай хоногийн хамгийн их тунадасны хэмжээг ***$H_{1\%}$=125 мм*** гэж авав.

200 км^2-аас бага ус хураах талбайтай гол горхи, сайруудын үерийн хамгийн их урсацын тооцоог "Ус зүйн тодорхойлолтуудыг тооцоолох норм ба дүрэм" БНбД 2,01,14-86-д заасны дагуу хур борооны эрчимшилтийн аргыг ашиглан тооцов.

Ус хурах талбайн гидрографын үзүүлэлтүүд болон хамгийн их урсацын тооцоог 1 дүгээр хүснэгт-д үзүүлэв.

Сайрын гидрографын үзүүлэлт ба төрөл бүрийн хангамшилтай хамгийн их урсацын хэмжээ

Хүснэгт-3

Сайр нэр	Ус хурах талбай км^2	Сайрын урт км	Сайрын хэвгий ‰	Төрөл бүрийн хангамшилтай өнгөрөлт м^3/с		
				Хангамшил %		
				1	2	5
Цагаан гол	156.1	40	58	51.01	44.38	32.14
Модотын сайр	36.2	14.8	51.4	13.49	11.73	8.50

3.3 Ууршилт.

Усны гадрагаас ууршиж ууршилт нь харьцангуй чиг, салхины хурдаас хамаарна. Томоохон нууруудаас хийсэн судалгаагаар Их нууруудын хотгор Хар нуурын усны ууршилт 1118 мм/жил байна.

Ихэс нуурын орчимд 1100 мм/жил хэмжээтэй ус ууршина гэж тооцоонд ашиглах нь зүйтэй.

4. ТАЛБАЙН ИНЖЕНЕР ГЕОЛОГИ

Талбайн ихэнх хэсгээр дөрөвдөгч галвын үеийн делюви –пролювийн болон алюви–нуурын хурдас ихэвчлэн тархсан байна. Делюви – пролювийн хурдас нь ихэвчлэн талбайн баруун урд захаар тархсан байхад алюви-нуурын хурдас нь талбайн дунд ба зүүн урд захаар илэрч байна. Талбайн баруун урд захаар одоо үеийн салхины үйл ажиллагаагаар хуримтлагдсан нарийн ширхэгтэй элс их биш зузаантайгаар тархсан байна. Талбайд цооногуудыг 6-10.5 м-ийн гүнтэй өрөмдөхөд геологийн тогтоц нь дараах байдлаар илэрхийлж байна. Үүнд:

- 1-р үе 10-15%-ийн хайрга бүхий цайвар бор өнгийн хөнгөн шавранцар, элсэнцэр үе 0.3-0.5 м-ийн зузаантайгаар тархсан байна. Шавранцар ба элсэнцэр үеийн зузаан нь нуур тийшээ ойртох тутам ихсэж байна.
- 2-р үе 20-25% -ийн хайрга бүхий нарийн ширхэгтэй элсэн үе 2.0-4.0 м-ийн зузаантайгаар тархсан байна.
- 3-р үе янз бүрийн ширхэгтэй элс бүхий хайрга, хайрганцар үе 5-6 м-ийн зузаантайгаар илэрч байна.

Харин Ихэс нуурт ойртох тутам нарийн ширхэгтэй элс, янз бүрийн ширхэгтэй элс нь элсэнцэр ба элс шавранцар бүхий үеэнд алгуур шилжиж байна. Делюви- пролювийн хурдас нь талбайн баруун урд буюу уулын бэлрүү ойртох тутам ихсэж нуурлуугаа бага биш зузаантайгаар илэрч байгаа ба ширхэгийн бүрэлдэхүүн нь бэлээсээ нуур тийш диаметр нь багасаж байна. Талбайн зонхилох чулуугийн физик механикийн шинж чанарыг доорх хүснэгтээр үзүүлэв

Хөнгөн шавранцар ба элсэнцэр

Хувийн жин	2,75 г/см3
Эзэлхүүн жин	нягт1,32 г/см3, сийрэг 1.48г/см3
Уян налархай	Тогтворгүй дээд хязгаар 24,10
	Илрэлтийн доод хязгаар 22,10
	Уян налархайн тоо 12,0
Нуралтын өнцөг	Усан доор 350, Хуурай газар 260
Шүүрэлтийн коэффициент	0,58-0,76 м/хоног
Сүвэрхэг чанар	нягт 36.2 % сийрэг 43.1%

Хайрга хайрганцар бүхий нарийн ширхэгтэй элс

Хувийн жин	2,70 г/см3
Эзэлхүүн жин	Нягт 1,78 г/см3 сийрэг 1,51 г/см3
Нуралтын өнцөг	Усан доор 310, Хуурай газар 390
Шүүрэлтийн коэффициент	10,6-14,3 м/хоног
Сүвэрхэг чанар	нягт 33.6 % сийрэг 42.1%

Янз бүрийн ширхэгтэй элс бүхий хайрга, хайрганцар

Хувийн жин	2,65 г/см^3
Эзэлхүүн жин	нягт1,78 г/см^3 сийрэг 1,44 г/см^3
Нуралтын өнцөг	Усан доор 35^0, Хуурай газар 26^0
Шүүрэлтийн коэффициент	16-21,3 м/хоног
Сүвэрхэг чанар	Нягт 34 %, сийрэг 46%

Услагдах талбай геоморфологийн хувьд тэгшивтэр, бага зэргийн налуутай тэвшин хэлбэртэй хөндийн хэв шинжинд багтана. Хажуугийн уулсын бэл нь хөндийн ёроолд эгц мөргөцөг үүсэхгүй, алгуур шилжиж байна. Талбайн баруун хэсэг буюу Ихэс нуурын баруун урд тал нь өндөр уулаас буух үеийн усны нөлөөгөөр үүссэн олон жижиг сайруудаар зүсэгдэлтээс гадна сайрууд нь дээшлэх тутам гүнзгий эгц эрэгтэй болдог. Сайруудын адагт хушуурсан хурдас үүсч улмаар уулын хөндий рүү түрж орсон хэлбэртэй байна.

4.1 Талбайн гидрогеологийн нөхцөл

Талбайд өрөмдсөн цооногуудад хөрсний ус янз бүрийн гүнд илэрсэн байна. Талбайн баруун урд захаар 10.5м хүртэл өрөмдөхөд ул хөрсний ус илрэхгүй байхад харин бусад хэсэгт өрөмдсөн цооногуудад 3.9-7.5 м-ийн гүнд илэрч байна. Ул хөрсний ус нь даралтгүй илэрсэн байна. Уст үеийн чулуулаг нь ихэвчлэн делюви-пролювийн хурдас байгаа бөгөөд энэ нь уул орчимдоо зузаарч хөндий рүү зузаан нь багасаж байна. Энэ үеийн ус нь сайраар урсаж ирсэн ус, цас борооны усаар голчлон тэжээгддэг байна. Ул хөрсний урсгалын чиглэл нь гадаргуудаа ижилхэн байна. Талбайн баруун урд захаар 12.0 м хүртэл өрөмдөхөд делюви-пролювийн хурдсанд ус илрэхгүй байгаа нь уулын бэлээс хөндий рүү дөхөх тутам ус шүүрүүлэх чадвар ихтэй том ширхэгтэй элс бүхий хайрган үе давамгайлж байгаагаар тайлбарлагдана.

5. ХӨРСНИЙ МЕЛИОРАЦИЙН СУДАЛГАА БА ТАРИМЛЫН УСАЛГААНЫ ГОРИМ, НОРМ

5.1 Хөрс мелиорацийн нөхцөл

Талбайн хөрсний бүрхэвч нь алюви ба долювийн хурдсаас тогтсон ихэнхи хэсэгт дунд зэргийн ба хөнгөн шавранцар, зарим хэсэгтээ элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй цэвэр бор хөрс болно. Ялзмагт үе давхаргын зузаан нь (А+В)=20-30 см. Энэ давхарга нь шавранцар ба элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй, бат бэх биш бутрамхай бүтэцтэй, дунд зэргийн нягтарсан жижиг үйрмэг чулуу багаар (8.4-12.3%) агуулсан байна.

Дэвсэгдэгч чулуулаг нь 40-45 см үе давхарганаас эхлэн янз бүрийн ширхэгтэй элсэн хурдас нь хайрга 20-25%-ийг агуулсан байна. Давсны хүчлийн 10%-ийн уусмалын үйлчилгээнд өнгөнөөсөө 20 см хүртэл үе давхарганд сулавтар доошлох үе давхаргандаа дунд зэрэг буцалдаг байна. Өмнө хийгдсэн хайгуул судалгаагаар хөрсний байгалийн чийг нь 0.4м-ийн гүнд 5.5-2.3%, хээрийн чийг багтаамжил 18.2%, гэж тооцоолон гаргаж байсан байна.

Өмнө хийгдсэн хайгуул судалгаагаар талбайн хөрсний шинжилгээг 9 цэгээс дээж аван Усны хайгуул төсөл, эрдэм шинжилгээний институтэд(хуучин нэрээр)

- Ялзмаг – Тюрины арга, %
- Нитрат азот ($N\text{-}NO_3$) - Инометрийн арга, мг/кг
- Хөдөлгөөнт фосфор (P_2O_5) - Мачигины арга, мг/100г
- Хөрсний орчин (PH) - усан хандмалд инометрийн арга
- Давсжилт - Инометрийн арга
- Хөдөлгөөнт кали(K_2O) – Дөлт Фотометрийн арга, мг/100г
- Механик бүрэлдэхүүнийг Качинскийн аргаар тус тус

тодорхойлж лабораторын дүгнэлт гаргажээ

Лабораторын шинжилгээний дүнгээс харахад хөрсний үе давхаргууд дараах шинжийг хадгалж байна:

А -Ялзмагийн давхарга, дээд хэсэг нь ямар нэг хэмжээгээр хатуурсан, зарим хэсэгтээ өнгөн үе маш нягт сийрэгжиж хатуурсан бор саарал өнгөтэй бөөмөрхөг үрлэн бүтэц сул илэрсэн,хөнгөн шавранцараас элсэнцэр болтлоо механик бүтэц нь өөрчлөгдсөн, үндсэрхэг, хэмхдэс сайр чулуу бага агуулсан, бага зэрэг давсжсан, 18-22см зузаантай ялзмаг харьцангуй багатай (1.18-1.379) тод биш илрэц бүхий үе болно.

В - Шилжилтийн давхарга, гол төлөв бор саарал, цайвар бор өнгөтэй хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй , нягтавтар, сайр чулуутай, бага зэрэг давсжсан 20-30см зузаан үе болно

ВС – Шилжилтийн давхарга, цайвар өнгөтэй ,заримдаа зосорхог ба зэгэл сааралдуу толботой,сайр чулуу ихтэй (40-70% хүртэл)хөрс үүсгэгч эх чулуулгийн шинж давамгайлж хөнгөн шавранцар ба элсэнцэр бүрэлдэхүүнтэй, үндэс цөөн.Үүний доод талд элювийн ба элюви-делювийн сайр чулуурхаг нимгэн хурдсаас тогтсон хөрс үүсгэгч эх чулуулгийн давхарга С оршино .

Энэхүү талбай нь ялзмаг багатай, фосфорын хангамж муу, нитратын болон калийн хангамж дунд зэрэгтэй хөрстэй бөгөөд сүүлийн жилүүдэд атаршиж салхины элэгдэлд орсон тул агромелиорацийн нэмэгдэл арга хэмжээг зайлшгүй авах хэрэгтэй болно.

Шурф [1]	Дээж авсан гүн	10,0 м	10-7	7-5	5-3	3-2	2-1	1-0,5	0,5-0,25	0,25-0,1	0,1-0,05	0,05-0,01	0,01-0,005	0,005-0,001	0,001	Хөрсний тодорхойлолт
Ш-1	0-25	8,6	4,3	4,3	6,8	6,8	12,3	4,0	12,0	12,6	11,4	2,0	8,0	6,0	6,1	Элсэнцэр
	30-50	12,8	5,7	5,0	9,3	8,6	14,0	4,5	10,3	11,7	7,4	1,2	1,4	3,8	4,3	Элс
	70-90	34,2	6,8	6,8	9,9	8,6	12,0	4,6	6,7	4,2	1,8	6,2	0,6	1,3	1,5	Элс
Ш-4	0-15	22,1	4,0	2,6	4,3	2,1	8,0	2,3	7,9	13,0	16,4	2,6	1,4	7,8	5,1	Элсэнцэр
	20-30	12,8	7,1	5,0	8,6	6,0	9,3	2,6	8,2	9,3	12,0	5,9	1,9	7,1	4,2	Элсэнцэр
Ш-6	0-20	7,1	7,4	5,0	6,4	4,3	7,7	1,9	6,2	10,0	6,7	10,7	2,7	13,5	10,4	Дунд зэр.шав-р
	30-50	6,2	7,1	8,6	11,4	8,6	16,3	5,4	10,0	5,0	6,1	1,0	1,0	6,4	6,9	Элсэнцэр
	80-100	12,8	5,1	4,3	8,0	7,1	9,3	2,1	5,8	6,3	10,1	10,4	2,9	9,1	6,1	Элсэнцэр
Ш-8	0-25	-	-	-	-	1,1	2,9	1,0	2,9	4,8	16,4	24,5	6,5	24,5	15,4	Дунд зэр.шав-р
	35-55	10,0	5,0	2,9	5,0	3,4	10,6	3,2	5,1	8,9	11,7	10,2	0,2	13,4	10,4	Хөнгөн шавранцар
	70-100	17,7	5,7	4,8	7,1	7,1	5,7	1,5	2,1	2,1	4,8	9,4	5,0	14,2	12,8	Хөнгөн шавранцар
Ш-11	0-25	11,7	2,9	8,5	8,5	6,5	13,7	0,6	1,2	3,5	4,3	15,1	8,7	14,4	10,4	Дунд зэр.шав-р
	25-40	28,6	5,5	4,5	6,2	5,0	14,2	1,4	5,1	6,8	2,9	5,9	0,7	6,8	6,4	Элсэнцэр
	60-100	20,5	10,5	6,2	14,0	8,5	20,2	4,0	7,0	3,4	1,3	0,6	-	2,4	1,1	Элс
Ш-16	0-25	-	6,5	6,0	7,7	5,7	20,0	0,2	1,7	3,3	2,6	19,6	3,2	14,1	10,4	Хөнгөн шавранцар
	30-50	7,7	2,6	4,3	10,6	11,4	24,2	-	0,2	1,6	1,3	11,0	5,7	1,3	10,1	Хөнгөн шавранцар
Ш-18	0-25	9,4	6,7	5,9	7,2	5,6	10,0	-	-	-	-	-	-	-	-	Хөнгөн шавранцар
	40-80	5,1	2,9	2,0	11,0	10,0	31,4	0,4	1,3	4,5	0,6	14,9	0,8	8,0	7,1	
Ш-13	0-30	11,4	2,9	3,4	1,1	7,1	25,7	0,4	2,5	3,3	6,0	10,9	1,1	1,1	8,3	Хөнгөн шавранцар
	30-55	21,9	10,4	7,7	9,1	6,3	11,2	1,2	5,5	4,1	3,4	2,9	-	-	4,2	Элс

Хөрсний Арго-химийн үзүүлэлтийг тодорхойлох хүснэгт(100 гр хөрсөнд)

Шурф	Дээж авсан гүн, м	Фосфор	Калий	Азот	Ялгамагнийн %	CO_2 карбонат	pH
Ш-1	0-25	2,08	9,6	2,4	1,98	0,76	6,8
	30-50	1,04	12,0	2,4	1,10	1,21	6,9
	70-90	0,88	12,0	1,2	0,98	0,81	7,1
Ш-4	0-15	1,36	9,6	1,8	2,7	1,42	7,2
	20-30	0,72	9,6	1,8	1,27	0,52	7,2
Ш-6	0-20	1,52	12,0	1,8	2,72	3,92	7,1
	30-50	0,64	9,6	1,8	1,72	2,83	7,1
	80-100	0,48	9,6	1,8	1,15	3,04	7,1
Ш-8	0-25	1,08	9,6	1,8	1,73	3,94	7,1
	35-55	0,8	7,2	1,8	1,39	3,73	7,0
Ш-11	0-25	2,24	9,6	2,4	1,44	3,93	7,3
	25-40	0,96	12,0	2,4	1,14	0,09	7,4
	60-100	0,56	12,0	2,4	1,14	0,49	7,4
Ш-14	0-25	1,20	9,6	1,8	1,65	4,99	7,5
	30-50	0,72	9,6	1,8	2,23	2,41	7,5
Ш-18	0-25	1,12	12,0	1,8	2,23	2,41	7,5
	40-80	1,28	12,0	1,8	1,98	0,85	7,2
Ш-13	0-30	1,78	9,6	1,2	1,92	3,18	7,2
	30-55	1,52	9,6	1,2	1,94	0,71	7,2
	80-120	-	-	-	-	0,72	7,2

Хөрсний ус физикийн шинж чанарын үзүүлэлтийн нэгтгэсэн хүснэгт

Тоолсон үеийн зузаан см	Эзлэхүүн жин г/см³	Хуваалт жин г/см³	Хөрсний чийгийн эзлэхүүн жингээр сүвэрхэг тодорхойлсон хувь %				чийг багтаамжийн ус хязгаар мм/га
			Байгалийн чийг	чийг багтаамж	Ерөнхий хувь	Агааршилт	
0-20	1,44	2,75	6,6	13,2	47,6	34,4	264
20-40	1,64	2,70	2,1	12,0	36,6	26,7	480

Хөрсний ус физикийн шинж чанарын үндсэн тодорхойлогч хүснэгт

Тодорхойлолт	Үеийн зузаан см	
	0-20	20-40
Сүвэрхэг чанар	47,6	38,8
Хээрийн чийг багтаамж	26,4	40,4
Усалгаа хоорондох хугацаанд хөрсний хатаалтын дээд хязгаар / хээрийн чийг багтаамж/	70	70
Усалгааны норм залруулгагүйгээр	79	144
Усалгааны норм залруулгатайгаар /ууршилтын коэф-т 1.4/	110	200

Эдэлбэрлэх арга хэмжээ

1. Услагдах талбай нь хөрсний үржил шимийн цөм болсон ялзмагийн агуулалт багатай (<1.5%) байгаа тул хөрсийг аль болохоор эрдэс болон шим бордоогоор ахиухан бордох шаардлагатай. Талбайн дээд хэсгээр байрлах хөнгөн механик бүрэлдэхүүнтэй 610 га талбайд азот 210кг/га, фосфор 190кг/га, кали 105кг/га үйлчлэх бодисоор, доод хэсгээр байрлах элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй 410га талбайд азот 280кг/га, фосфор 236кг/га, кали 130кг/га үйлчлэх бодисоор тооцож бордох
2. Талбайн хөрс атаршиж нягтаршсан тул ашиглалтын эхний жилд эргүүлэн хагалж цаашид зөвхөн хавж хагалж байх.Талбайд гадаргуугийн тэгшилгээ хийх шаардлагагүй бөгөөд гагцхүү хагалгаа, үрэлгээний чиглэлийг тухай бүр зөв тогтоож талбайн гадаргууг аль болох ховилгүй тэгш байлгахад анхаарч байх

5.2 Мелиорацийн мужийн тухай ойлголт

Монгол орны мелиорацийн бүс, бүсчлэлийг анх 1982 онд тэр үеийн Усны хайгуул төсөл, эрдэм шинжилгээний институт, Бэлчээр тэжээлийн ЭШХ, Ургамал газар тариалангийн ЭШХ хамтран боловсруулж батлуулснаас хойш одоог хүртэл шинэчлэгдээгүй байна

Хөрсний ус-агаарын горимыг тохируулах замаар байгалийн нөхцлийг өөрчлөн сайжруулж таримал ургамлын ургах таатай орчин нөхцлийг буй болгох зорилгоор онол, практикийн асуудлуудыг судлаж, нэгтгэн дүгнэж байгаа шинжлэх ухааны нэг салбар нь мелиорацийн шинжлэх ухаан юм.

Мелиорацийн бүсчлэлийн үндсэн зорилго бол таримлын усалгааны норм, горимыг тухайн бүс нутгийн хөрс, байгаль цаг уурын онцлогт тохируулан таримлын төрөл тус бүрээр тодорхойлох явдал юм. Таримлын усалгааны норм, горим бүс нутгийн хөрс, түүний чийгшлийн зэрэг, ууршуулах чадвар, нарны эрчим, салхины хурд, зайц, давтамж зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг.

Услалтын мелиораци нь усаар дутмаг, хуурай уур амьсгалтай газрыг зохих хэмжээний усаар хангаж, ургамалд шаардагдах чийгийн нөөцийг хөрсөнд бий болгож, тарьсан ургамлаас жигд, тогтмол өндөр ургац авах зорилтыг хангана.

Услалтын мелиорацийг явуулахад хөрсөнд шаардагдах ус чийг, шим тэжээл, агаар, гэрэл, температур зэрэг үндсэн таван нөхцлийг тохируулж байх шаардлагатай. Чийгийг хөрсөнд тогтмол байлгах нь хөрсний дулаан, чийгийн ууршилтыг нэмэгдүүлэх, ургамлын хэвийн ургалтыг хангахад чухал ач холбогдолтой.

Усалгаа нь хөрсний физик, хими, биохими, биологийн үйл явцад олон янзын чухал нөлөө үзүүлнэ. Тухайлбал, чийглэг, температур, дулаан шингээлт, хөрсний механик чанар, бүтэц, сүвэгшилт, ус нэвтрүүлэх чадвар, усыг тогтоон барих чадвар, хөрсний жижиг хэсгүүдийн барьцалдах чадвар, хөрсний эрдэс бодисын агууламж, ул хөрсний усны түвшний өөрчлөлт, түүний эрдэсжилтийн байдал зэрэгт өөрчлөлт үзүүлнэ. Услалтын улмаас хөрсний дулааны горим өөрчлөгдөж хөрсний дулаан шингээх чадвар нэмэгддэг.

Дулаан шингээлтээрээ хуурай хөрс, чийгтэй хөрснөөс бага байна. Ус дулаан шингээлт ихтэй тул тухайн цаг үед байгаа усны температур нь агаарын температураас ямагт их байдагт оршино.

Монгол орны нутаг дэвсгэрийг байгалийн чийг ба дулааны баланс, чийгшлийн коэффициентийн утга, байгалийн бүс, жилд болон дулааны улиралд унах хур тунадасны хэмжээ, цельсийн +10.0 градусаас дээшхи идэвхитэй температурын нийлбэр зэрэг үзүүлэлтүүдээс хамааруулан мелиорацийн 5 бүс болгон хуваасан байдаг.

• 0-60 см үе давхрага дахь усалгааны өмнөх хөрсний чийгийн босгыг 70.0 хувиас доош оруулахгүй бариулж услах нрм нь 400 м3/га, 60.0 хувиас доош оруулахгүй бариулж услах норм нь 530 м3/га байна.

6. ТАРИМЛЫН УС ХЭРЭГЛЭЭ БА УСАЛГААНЫ ГОРИМ, НОРМ

6.1 Таримлын ус хэрэглээний коэффициент

Таримал ургамал бүр ургалтынхаа хугацаанд харилцан адилгүй хэмжээний ус хэрэглэдэг бөгөөд ургамлыг усаар бүрэн хангах нь өндөр ургац бүрдүүлэх нөхцлийн нэг байдаг. Таримлын ус хэрэглээг транспирацын коэффициент ба ус хэрэглээний коэффициент гэсэн үзүүлэлтүүдээр илэрхийлж, тоон утгаар хэмжээг нь харуулдаг. Ус хэрэглээний коэффициент гэдэг нь 1.0 тн эсвэл 1.0 цн ургац бий болгохын тулд зарцуулсан усны хэмжээ юм. Энэ нь м3/тн, м3/цн гэсэн нэгжээр илэрхийлэгдэнэ. Коэффициентийн утга таримал бүрт өөр өөр байдгаар зогсохгүй нэг төрлийн таримлын хувьд ч ургалтын хугацааны цаг агаарын өөрчлөлт, хөрсний үржил шимийн хангамж зэрэг олон нөлөөллөөс хамааран өөрчлөгддөг. Тодруулбал, таримлын амьдралыг тэтгэгч хүчин зүйлсийн хэрэгцээ хэдий чинээ сайн хангагдах тусам нэгж бүтээгдэхүүнд зарцуулагдах ус чийгийн хэмжээ төдий чинээ багасдаг. Эсрэг тохиолдолд ургамлын ус хэрэглээ өсдөг. Ус хэрэглээний коэффициентийг дараах томъёогоор тодорхойлдог.

$$\text{Кух} = \sum E : У$$

Энд: ∑Е – таримлын нийлбэр ус хэрэглээ (мм/цн, м3/тн)

У – аж ахуйн ашигт ургацын хэмжээ (тн/га, цн/га)

Зарим төрлийн таримлын ус хэрэглээний коэффициент (М.К.Каюмовынхоор)

Таримлын төрөл	Жилийн төлөв (мм*га/цн)		
	Услаг жил	Дунд зэргийн жил	Гандуу жил
Зусах буудай	350-400	400-465	435-500
Арвай	375-425	435-500	470-530
Хошуу будаа	435-450	500-550	530-590
Эрдэнэ шиш /ногоон тэжээлд	350-400	400-500	500-600
Төмс	400-450	450-500	500-550
Олон наст өвс /хадланд/	500-550	500-650	700-750
Олон наст өвс /хадланд/	500-550	500-650	700-750
Олон наст өвс /бэлчээрт/	125-140	140-165	175-190

6.2 Таримлын нийт ус хэрэглээ

Ургамлын ургалтын хугацаанд хөрсний гадарга ба ургамлаар дамжин ууршиж алдагдах ус чийгийн хэмжээг нийт ууршилт буюу таримлын нийт ус хэрэглээ гэнэ. Таримлын нийт ус хэрэглээ буюу нийт ууршилт /эвопотранспираци/ нь тухайн бүсдээ нилээд тогтвортой үзүүлэлт байдаг бөгөөд энэ нь агаарын ба хөрсний температур, агаарын харьцангуй чийг, хур тунадас зэрэг цаг уурын нөхцөлөөс хамаардаг.

Түүнээс гадна тухайн таримлын нийт усны хэрэглээ, ус чийгэнд тавих сортын биологийн онцлог, бүрдэх ургацын хэмжээ, хөрсний үржил шим, агротехникийн түвшингээс хамаарч өөрчлөгддөг. Нийт ус хэрэглээг тодорхойлох хэд хэдэн аргууд байдаг бөгөөд манайд нилээд өргөн хэрэглэдэг нь Оросын эрдэмтэн А.Н Костяковын арга юм. Тухайлбал, ус хэрэглээний коэффициент, аж ахуйн ургацын хэмжээг мэдэж байгаа тохиолдолд нийт ус хэрэглээг дараах томъёогоор тооцож олно.

$$\sum E = У \cdot kух$$

Энд: ∑Е - нийт ус хэрэглээ /нийт ууршилт/, (м3/га)

У - төлөвлөгөөт эсвэл бодит ургац, (тн/га эсвэл цн/га)

kух – таримлын ус хэрэглээний коэффициент, (мм/цн)

Таримлын нийт ус хэрэглээг мэдсэний үндсэн дээр ургамал ургах хугацаанд тухайн таримал, сорт нь хур тунадас, хөрсөнд байгаа чийгээс гадна усалгаагаар хичнээн хэмжээний ус шаардахыг /услалтын нормыг/ тодорхойлж гаргана.

Хөрсний тооцоот давхрагад агуулагдах чийгийн хэмжээг хэмжиж тодорхойлсон тоо мэдээнд тулгуурлан нийт ус хэрэглээг дараах томъёогоор боддог.

$$\sum E = Wo - Wk + M + \sum От$$

Энд,

Wo – ургамал ургалтын хугацааны эхэнд хөрсний тооцоот давхрагад агуулагдаж байсан чийгийн нийт нөөц (мм, м3/га)

Wk – ургамал ургалтын хугацааны эцэст хөрсний тооцоот давхрагад агуулагдаж байсан чийгийн нийт нөөц (мм, м3/га)

M – таримлын услалтын норм (мм, м3/га)

∑От – ургамал ургалтын хугацаанд орсон хур тунадасны нийлбэр (мм)

$$\mathbf{Wk = 0.1 \cdot \sum(Bk \cdot d \cdot h)}$$

Энд,

Bk – ургамал ургалтын хугацааны эцэст хөрсний тооцоот үе давхрагад агуулагдаж байсан чийгийн нийт нөөц (мм, м3/га)

d – хөрсний тооцоот үе давхрагын эзэлхүүн жин (гр/см3)

h – чийг тодорхойлсон хөрсний тооцоот үе давхрагын зузаан (см)

$$\mathbf{Wo = 0.1 \cdot \sum(Bo \cdot d \cdot h)}$$

Энд,

Во – ургамал ургалтын хугацааны эхэнд хөрсний тооцоот үе давхрагад агуулагдаж байсан чийгийн нийт нөөц (мм, м3/га)

Тариалангийн хөрсөнд агуулагдах чийгийг нийт чийг, бүтээгдэхүүнт чийг гэж ерөнхийд нь хоѐр хэсэгт хуваадаг. Бүтээгдэхүүнт чийгийн нөөцийг дараах томъѐогоор тодорхойлно.

$$\mathbf{W = W_н + P * KP + QЧ – W_к}$$

Энд,

WH – ургалтын хугацааны эхэнд хөрсний метрийн гүнд байсан нөөц чийг [мм]

P – ургалтын хугацаанд орсон тунадас [мм]

KP – тунадас ашиглалтын коэффициент (дунджаар 0.75 гэж тооцож болно)

QЧ – гүний уснаас ирэх чийг [мм]

Wк – ургалтын хугацааны сүүлд байсан нөөц чийг [мм]

Таримлын нийлбэр ус хэрэглээг А.Н.Костяковын дээрх аргуудаас гадна ургамлын биомассын илчлэг, агаарын идэвхитэй дулааны нийлбэр зэрэг үзүүлэлтүүдийг ашиглан дараах аргуудаар тодорхойлж болдог.

a) ∑E = (105 · R) : Кдд
b) ∑E = Кчз · ∑to>10oC
c) ∑E = 0.1 · Убиол · E1

$$\mathbf{E1 = (100 \cdot q) \cdot (Кдд \cdot \eta)}$$

Энд

R – идэвхитэй температурын ашиглалтын коэффициент,

R = 0.013 · ∑to >10oC

Кдд – 2453 – ууршилтын далд дулааны коэффициент [кДж/кг, (586 ккал/кг)]

Кчз – тооцоот хугацааны /ургамал ургалтын хугацааны турш дахь, эсвэл чийгийн хэмжилт хийсэн хугацааны хооронд/ хөрсний чийгийн зарцуулалтын коэффициент ∑to>10oC – тооцоот хугацааны /ургамал ургалтын хугацааны турш дахь, эсвэл чийгийн хэмжилт хийсэн хугацааны хооронд/ 10 градусаас дээшхи идэвхитэй температурын нийлбэр

Убиол – таримлын нийт биомасс

E1 – 1 кг хуурай биомасс бүрдэхэд зарцуулагдсан ус хэрэглээ

q – биомассын илчлэг (кДж/кг)

η – таримлын ФИЦ ашиглалтын а.ү.к

Манай орны нөхцөлд үр тарианы таримлын ус хэрэглээ ба услалтын нормыг мелиорацийн бүс бүрээр жишиг байдлаар тогтоосон байдгийг ашиглан тариалан эрхэлж байгаа бүс нутагтаа нийлбэр ус хэрэглээг тодорхойлох бололцоотой.

6.3 Таримлын усалгааны горим, норм

Усалгааны горимыг зөв бариулсанаар өндөр ургац авах боломж бүрддэг. Усалгааны горим гэдэг нь услах хугацаа, усалгааны ба услалтын норм, услах тоог хамарсан ∫( ) ойлголт юм. Усалгааны горимыг зохистой хэмжээнд барьснаар хөрсөнд ус, агаарын тохиромжтой харьцаа бий болж улмаар өндөр ургац авах, бүтээгдэхүүний өөрийн өртгийг хямдруулах хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхэд ихээхэн ач холбогдолтой юм.

Усалгааг хөрсний хээрийн чийгийн багтаамж хүртэл хийж болох ба харин түүнээс илүү нормоор хийвэл ургамалын өсөлтийн бүх процессд шууд эсрэг нөлөө үзүүлхээс гадна эдийн засгийн хувьд алдагдалтай болдог.

Усалгааны норм багадвал ургац эрс багасна. Харин хөрсний чийгийн доод хязгаар буюу ээлжит усалгаа эхлэхийн өмнөх үеийн чийгийн хэмжээ нь ургамлын биологийн онцлог түүний хөгжлийн үе шат, экологийн болон техник эдийн засгийн нөхцөлөөс хамаардаг. Иймд усалгааны нормыг зөв тогтоох èстой.

Усалгааны норм гэж нэг удаагийн усалгаагаар талбайд өгсөн усны хэмжээг хэлдэг бөгөөд энэ нь хөрсний хээрийн чийг багтаамшил (ХЧБ), хөрсний чийгийн зөвшөөрөгдөх доод хязгаар, услах үе давхрагын зузаан, таримлын биологийн онцлог, хөрсний эзэлхүүн жин зэргээс хамаардаг. Хөрсний услах үеийн зузааныг ургамлын үндэсний системийн өсөлт хөгжилт, ургамалын төрлөөс хамааруулан сонгоно.

Усалгааны нормыг тооцохдоо доорх томъèог ашигладаг.

$$m=100*\alpha*h(W_{ХЧБ}-W_Б)*K_у$$

Энд,

m - Усалгааны норм, (м3га)

h - Хөрсний тооцоот давхрагын зузаан. (м). Таримлын үндэсний өсөлтөөс хамаарч ургалтын эхэн үед 0.4 м, ургалтын дундаас хойш 0.6-1.0 м үе давхрагад тооцно.

α - хөрснний ээлхүүн жин, (г/см3). Энэ нь манай нөхцөлд 1.2-1.4 г/см3

$W_{ХЧБ}$ - хөрсний тооцоот давхрагын хээрийн чийг багтаамж (%), Энэ нь элсэнцэр хөрсөнд 6-15%, шавранцар хөрсөнд 15-30% байна.

$W_Б$ - Услахын өмнө хөрсний тооцоот давхрагад байгаа бодит чийг (%). Үүнийг хөрсний чийгийн дээж авч тодорхойлно.

Ку – Усалгааны усны ууршилтын алдагдлыг тооцох коэффициент. Манай орны нөхцөлд цаг агаар гандуу үед Ку=0.3, ердийн үед Ку=0.17, чийглэг үед Ку=0.05 гэж авна. [Д.Төмөр, Л.Жанчивдорж, Ш.Баранчулуун, М.Дугармаа].

Усалгаатай талбайгаас арвин ургац хураахын тулд зуны турш хөрсний чийгийг ХЧБ-ийн зохих хэмжээнд тогтмол байлгах хэрэгтэй. Хөрсний чийгийг энэ хэмжээнээс бууруулахгүй барихад услах хугацааг зөв тогтоох явдал чухал юм. Тухайн жилийн цаг уурын байдал, таримал сортын онцлогоос ургалтын хугацааны усалгааны тоо хамаарна. Ургамал ургах хугацаанд усалгаагаар өгч байгаа усны нийлбэр хэмжээг услалтын норм гэнэ. Энэ нь тухайн таримал, сортын биологийн онцлог, бүсийн хөрс цаг уурын нөхцлөөс шалтгаалдаг. Услалтын нормыг хөрсний гүний ус доор байрладаг нөхцөлд дараах томъèогоор олдог.

$$M=\sum E-(W_{ЭХ}-W_Т)-T$$

Энд,

М - услалтын норм, (м3га)

∑Е - нийт ус хэрэглээ, (м3га)

WЭХ – тариалалтын өмнө хөрсний тооцоот давхрагад агуулагдаж байсан хөрсний чийг, (м3га)

WТ – хураалтын өмнө хөрсний тооцоот давхрагад агуулагдаж байсан хөрсний чийг, (м3га)

Т - ургалтын хугацаанд орсон ашигтай тунадас, (м3га)

Услалтын нормыг ургамал ургалтын хугацаан дахь усалгааны норм ба усалсан тооны үржвэрээр тодорхойлж болдог.

$$M=m*n$$

Энд,

m – усалгааны норм (м3га).

n – усалгааны тоо

Гол нэрийн таримлын услалтын жишиг норм

Таримлын нэр	Мелиорацийн бүсээр		Газар зүйн бүсээр	
	II	III	Ойт хээр	Тал хээр
Үр тариа	1800-2000	2100-2400	1880-2000	2100-2400
Даршны таримал	1800-2200	2600-2900	1800-2000	2600-2900
Олон наст өвс	2400-2900	3000-3300	2400-2900	3000-3300
Тэжээлийн нэг наст	1500-1800	1900-2200	1500-1800	1800-2200
Төмс	2000-2400	2500-3000	2000-2400	2500-3000
Хүнсний ногоо	2200-2500	2600-3200	2200-2500	2600-3200

7. ЗУРАГ ТӨСЛИЙН ТЕХНИКИЙН ШИЙДЭЛ БА ҮЗҮҮЛЭЛТ

Харгана түрүүний услалтын систем нь цахилгаан эрчим хүчний төвлөрсөн эх үүсвэрээс зайтай оршдог бөгөөд түлш шатахуун зарцуулж ажилладаг усалгааны төхөөрөмжтэй, ашиглалтын зардал өндөртэй байсан нь ашиглагч байгууллага, тариаланчдад нэлээд хүндрэл бэрхшээл учруулдаг байжээ. Харгана түрүүгийн услалтын системийг өргөтгөх ажлын техникийн шийдлийг гаргахдаа захиалагч байгууллагын саналыг тэргүүн зэрэгт тавьж Дарив сумын засаг даргын тамгын газар болон, тариалан эрхлэх сонирхол бүхий сумын иргэдийн хүсэлт, сонирхлын дагуу услалтын системийг ил суваг шуудуугаар усаа авдаг, гар усалгаатай байхаар төсөлд тусгав.

Услах талбайн хамгийн өндөр цэг ба усан сан байгуулах газрын өндөр хоорондын харьцаанаас харахад ус өөрийн урсгалаар эдгээр цэгүүдийн хооронд урсах нөхцөл бүрдэх учраас Харгана түрүүгийн голоос дөхүүлэх сувгаар татан авч ус өгөх яндан хоолойгоор тээвэрлэн усан санд хүргэн усан сангаас ус авах хоолойгоор дамжуулан ил сувагт өөрийн урсгалаар талбайд хүргэх далд ба ил хосолмол сүлжээ байгуулах техникийн шийдлийг сонгов.

Таримлын онцлог, хөрсний төрөл, талбайн хэвгий зэргээс хамруулан хамарлах(аригаар услах), халиах, хайрцаглах зэрэг гадаргуугийн (гар) усалгааны аргыг хэрэглэнэ. Талбайг өмнө нь усалгаатайгаар ашиглаж байсан тул талбайд гадаргуугийн тэгшилгээ нэмж хийх шаардлагагүй.

7.1 Ус өгөх хоолой 1,2

Ус өгөх хоолойг эдэлгээний хугацаа урттай, тээвэрлэлтийн өртөг хямд, угсралтын ажил гүйцэтгэхэд түвэгшил багатай, температурын деформацийг сайн тэсвэрлэдэг, өндөр даралтад ажиллах чадвартай зэрэг үзүүлэлтүүдийг харгалзан полиэтилен хоолой PE100 маркийн хоолой тавихаар төсөлдсөн бөгөөд хоолойн диаметрийг гидравлик тооцооны үндсэн дээр эдийн засгийн хувьд хамгийн ашигтай нөхцөлөөр сонгов. Ус өгөх хоолой-1-ийн урт 106м, Ус өгөх хоолой-2-ийн урт 404 м байна.

7.2 Дөхүүлэх суваг

Баруун булгийн усыг дөхүүлэх сувгаар ус өгөх хоолой-1 т хүргэнэ. Дөхүүлэх сувгийн урт 60 м. Дөхүүлэх сувгийн доторлогоо нь бетон зуурмаган чигжээстэй чулуун өрлөг байна. Ёроолын өргөн 1-2м байна. Сувгийн хажуу налуу m=1.5 байна.

7.3 Гол суваг-1,2

Гол суваг-1 нь услагдах талбайн голоор гол суваг-2 нь услагдах талбайн зүүн захаар буюу талбайн хамгийн өндөр хэсгүүдэд байрлах бөгөөд чулуут бетон тэгш өнцөгт хөндлөн огтлолтой суваг байна. Сувгийн ёроолын өргөн 0.60м, гүн нь 0.60м, дүүргэлтийн гүн 0.42м байна.

7.4 Хувиарлах суваг

Хуваарилах суваг нь гол сувгаас усыг авч услагдах талбайд дөхүүлэх, талбай хооронд усыг хуваарилах зориулалттай баригдана. Хуваарилах суваг трапец огтлолтой доторлогоогүй суваг байна. Угаагдал үүсгэхгүйн тулд суваг дахь урсгалын дундаж хурд 0.60м/с-с хэтрэхгүй байна. Хуваарилах сувгийг суваг татагчаар гаргана.

7.5 Усан сан

Усан сангийн байрлал болон хэлбэр хэмжээг сонгож төлөвлөхдөө төслийн талбайтай танилцаж, захиалагч байгууллагын удирдлага, төлөөлүүдтэй уулзалт хийж тохиролцсон.

Усан сан-1-ийг талбайн дээд захад байрлах одоо байгаа усан сангийн хэлбэр хэмжээг засан сэргээж одоо байгаа 4000м3 эзлэхүүнийг 13182.2 м3 болгон нэмэгдүүлэхээр төлөвлөв.

Шинээр төлөвлөх Усан сан-2 нь 17814.6м3 эзлэхүүнтэй бөгөөд талбайн дунд орчим зүүн захад шинээр байгуулахаар төлөвлөв.

7.5.1 Усан сангийн хийц, зохиомж

Усан сан-1,2-ийн дотор талд нийтэд нь шүүрэлтээс хамгаалах 2.0 мм-ийн зузаантай HDPE геомембранаар доторлоно. Доторлогооны HDPE геомембраныг гэмтэхээс хамгаалж доор нь 300 гр/м2-ийн геотекстил дэвсэж өгөхөөр төлөвлөв.

7.5.2 Далангийн хийц

Хөрсний овоолго хийж байгуулах далангийн өндөр 1.5-2.2 м байх бол усан сан-1-ийн далангийн хярын өргөн 1681.00 м-ийн түвшинд 6 м, усан сан-2-ийн далангийн хярын өргөн 1660.50 м-ийн түвшинд 6 м,усан сангийн далангийн дотор налуу m=2.0, далангийн гадна налуу m=1.5 тус тус байна.

Шинээр усан сан байгуулах талбайн ургамлын өнгөн хөрсийг 10 см зузаан хуулж, захиалагчийн заасан газар зөөж овоолсны дараа далангийн суурийг сайтар тэгшилж, стандарт прокторын 90%-иас доошгүй хэмжээнд нягтруулж бэлдэнэ. Далангийн овоолго хийх хөрсийг тохиромжтой хөрс илэрсэн талбайгаас зөөвөрлөн авч ашиглана. Тохиромжтой хөрсийг зөөвөрлөн

Далангийн овоолго хийж дууссаны дараа Геотекстил болон HDPE геомембран дэвсэх талбайн гадаргууг сайтар цэвэрлэж стандарт прокторын 90%-иас багагүй хэмжээнд нягтруулж өгнө. Нягтруулж бэлдсэн газрын гадарга дээр 12.5 мм-ээс том ширхэглэлтэй хөрс, чулуулаг байж болохгүй. Далангийн дээд хашицын налуу дээр 300 гр/м^2-ийн геотекстил болон 2.0 мм зузаан HDPE геомембран суурилуулж сангийн ёроолын доторлогоотой холбож өгнө. Харин Геотекстил болон HDPE геомембраны дээд үзүүрийг далангийн хяр дээр 0.8х0.8 м траншейд хийж, дарж бэхэлж өгнө.

7.5.3 Сангийн ёроолын хийц

Усан санг байгуулахдаа сангийн ёроолын хөрсийг газрын гадаргаас хамаарч 0.3-1.1 м-ийн гүнтэй буюу ажлын зурагт заасан хэмжээ, түвшин хүртэл ухлагыг хийнэ. Сангийн ёроолын ухлагыг ажлын зурагт заасан түвшин хүртэл гүйцэтгээд газрын гадаргыг сайтар тэгшилж, стандарт прокторын 90%-иас багагүй хэмжээнд нягтруулж бэлдэнэ. Нягтруулж бэлдсэн талбай дээр 12.5 мм-ээс том ширхэглэлтэй хөрс, чулуулаг байж болохгүй. Сангийн ёроолын тэгшилж, нягтруулж бэлдсэн талбай дээр Геотекстил болон 2.0 мм зузаан HDPE геомембран суурилуулж далангийн дээд хашицын налуу дээр суурилуулсан доторлогоотой холбож өгнө.

8. АЖЛЫН ТЕХНОЛОГИ

Услалтын системийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэгч компани нь гэрээ болон ажлын зургийн дагуу гүйцэтгэнэ. Харин материалын болон талбайн туршилт, хяналт, судалгаа, шинжилгээний ажлыг хөрсний итгэмжлэгдсэн лабораториторой гуравдагч этгээдээр гүйцэтгүүлбэл зохимжтой.

8.1 Усан сан барих ажлын технологи

8.1.1 Газар шорооны ажил

Усан санг байгуулах ажлын ихэнх нь газар шорооны ажил байдаг бөгөөд энэхүү бүлэгт газар шорооны ажлын үед анхаарах, дагаж мөрдөх, туршилтын ажлуудын талаар тусгалаа.

8.1.2 Талбайн бэлтгэл ажил

Усан сан байгуулах талбайг бэлдэхдээ дараах зүйлсийг анхаарч ажиллана. Үүнд:

- Захиалагч болон Төсөл зохиогчийн төлөөллийг байлцуулж барилгын Улаан шугамыг тавьж, холбогдох акт болон бичиг баримтыг үйлдэх,
- Усан сангийн болон хөрс авч ашиглах карьерын талбайд өртөх бүхий л хатуу биет, модны хожуул, үндэс зэргийг цэвэрлэж зайлуулах,

Захиалагч болон зурагт төслийн төлөөлөгчид ажил эхлэхээс өмнө ашиглах хөрсний дараах туршилтуудыг гүйцэтгэн үр дүнг нь танилцуулна.

- Уян налархайн хязгаар, шингэний хязгаар, чийгийн агуулга
- Ширхэглэлийн бүрэлдэхүүн
- Хувийн жин
- Нягтруулалтын туршилт
- Шүүрэлтийн туршилт

Бүх туршилтын үзүүлэлтүүд нь захиалагчийн төлөөлөгчөөр зөвшөөрөгдсөн байх ёстой ба дахин нэмэлт туршилт хийх эсэхийг захиалагч шийдвэрлэнэ.

Лабораторийн туршилтын үр дүнд үндэслэсэн аргыг барилгын ажилд ашиглах боловч хөрсөнд тавигдах шаардлагыг хангаж ажиллана.

8.1.3 Шимт хөрс хуулах

Усан сан байгуулах талбайн шимт хөрсийг дунджаар 10-20 см зузаантай хуулахаар төлөвлөв. Хуулсан шимт хөрсийг захиалагчийн зааж өгсөн талбайд зөөж, тээвэрлэн овоолго үүсгэнэ.

8.1.4 Суурийн бэлтгэл

Усан сан байгуулах болон талбайг бэлдэхдээ дараах зүйлсийг анхаарч ажиллана. Үүнд:

- Усан сангийн суурийг Ажлын зурагт заасан өндөржилт хүртэл нь ухаж, овоолж бэлдэнэ.
- Суурийн талбайг нийтэд нь тохиромжтой чийг өгч, MNS ASTM D 698: 2002 стандарт туршилтын 90%-иас багагүй хэмжээнд хүртэл нягтруулж өгнө.
